



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/016/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086381
Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtei@audit.gov.mn

2025.03.25 № 130

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 4,970.3 мянган төгрөгөөр тасарсан,
- Хүү,торгуулийн орлого 668.3 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 3,621.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.
- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 198,357.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

8225020365

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 1,033,690.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,156,877.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 123,187.2 мянган төгрөгөөр буюу 112.0 хувьтай биелүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 1 орон тоо нэмэгдсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 320,177.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 30,834.1 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аймгаас авах санхүүжилтийг 30,834.1 мянган төгрөгөөр дутуу авсан боловч төсөвт байгууллагын санхүүжилтийг татварын давсан орлогоос бүрэн олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 500,802.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 12 хөтөлбөр 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 90.3 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-------|---|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,914,595.8 | 2,556,434.3 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 702,250.0 | 1,268,355.5 |
| 33 | АВЛАГА | 180,942.3 | 301,411.9 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 0.0 | 0.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 365,695.5 | 421,002.5 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 8,983.5 | 15,847.0 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 656,724.6 | 549,817.4 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,011,348.0 | 2,332,986.1 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,011,348.0 | 2,332,986.1 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,911,586.0 | 2,233,224.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 99,762.0 | 99,762.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,925,943.8 | 4,889,420.5 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 44,151.5 | 45,502.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 44,151.5 | 45,502.0 |
| 41300 | Өглөг | 44,151.5 | 45,502.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,881,792.4 | 4,843,918.5 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,881,792.4 | 4,843,918.5 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 305,025.6 | 305,025.6 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 3,573,704.6 | 4,536,785.8 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,062.2 | 2,107.1 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,925,943.8 | 4,889,420.5 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|---|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,866,648.4 | 4,678,994.0 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 760,018.6 | 1,153,460.1 |
| 110 | Орлогын албан татвар | 689,557.9 | 1,092,145.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 700,750.1 | 1,112,417.7 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (11,192.2) | (20,272.3) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 28,989.6 | 41,026.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 41,471.1 | 20,288.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 431,225.6 | 620,770.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 431,225.6 | 620,770.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,675,404.2 | 2,904,763.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,945,107.7 | 3,258,443.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,945,107.7 | 3,258,443.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 992,108.8 | 1,529,468.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 462,702.3 | 700,162.3 |
| 2102 | Ажил олгогчдос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,934.9 | 84,701.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 134,207.4 | 256,075.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 67,221.8 | 62,300.1 |
| 2105 | Нормативт зардал | 510.0 | 1,595.0 |

| | | | |
|------|--|-----------|-------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,993.6 | 57,438.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 24,230.0 | 24,440.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,762.6 | 52,998.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 161,546.2 | 289,756.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 952,998.9 | 1,728,974.9 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 921,540.7 | 1,420,550.6 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 445,200.2 | 655,208.1 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 476,340.6 | 765,342.5 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,618,438.7 | 2,569,682.7 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 760,018.6 | 1,152,545.9 |
| 110 | Орлогын албан татвар | 689,557.9 | 1,092,145.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 700,750.1 | 1,112,417.7 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (11,192.2) | (20,272.3) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 28,989.6 | 40,111.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 41,471.1 | 20,288.7 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,268.6 | 5,552.0 |
| 1181 | Газрын төлбөр | 3,977.0 | 14,670.6 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 36,225.5 | 66.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 183,015.9 | 163,488.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 183,015.9 | 163,488.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,675,404.2 | 1,253,648.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,793,108.2 | 1,447,362.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,793,108.2 | 1,447,362.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 840,109.3 | 1,379,782.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 461,550.3 | 691,006.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,934.9 | 85,173.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,797.1 | 263,545.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 58,630.8 | 62,183.9 |
| 2105 | Нормативт зардал | 510.0 | 1,595.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,832.5 | 58,720.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 24,230.0 | 24,440.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 198,425.0 | 52,623.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,198.7 | 140,494.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 952,998.9 | 67,579.5 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 825,330.4 | 1,122,320.3 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 474,688.3 | 556,214.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 474,688.3 | 556,214.8 |

| | | | |
|------|--|-------------|-------------|
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 474,688.3 | 556,214.8 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (474,688.3) | (556,214.8) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (98,000.0) | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 98,000.0 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 252,642.2 | 566,105.5 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 449,607.8 | 702,250.0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 702,250.0 | 1,268,355.5 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|---|-----------------------|------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,405,451.8 | 0.0 | 3,405,451.8 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,405,451.8 | 0.0 | 3,405,451.8 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 476,340.6 | 0.0 | 476,340.6 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,881,792.4 | 0.0 | 3,881,792.4 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,881,792.4 | 0.0 | 3,881,792.4 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 197,738.7 | 0.0 | 197,738.7 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,079,531.0 | 0.0 | 4,079,531.0 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (955.0) | 0.0 | (955.0) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 765,342.5 | 0.0 | 765,342.5 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,843,918.5 | 0.0 | 4,843,918.5 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|-----------------------------------|--------------|--------------|--------------|------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,969,007.30 | 1,875,803.22 | 1,093,204.08 | 63.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,491,920.00 | 1,365,869.79 | 126,050.21 | 91.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,412,538.40 | 1,298,290.33 | 114,248.07 | 91.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 749,646.50 | 691,006.17 | 58,640.34 | 92.2 |
| 210101 | Үндсэн цалин | 334,408.60 | 330,325.39 | 4,083.21 | 98.8 |
| 210102 | Нэмэгдэл | 278,779.30 | 251,693.69 | 27,085.61 | 90.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,674.00 | 13,728.00 | 11,946.00 | 53.5 |

| | | | | | |
|-------------|---|------------|------------|------------|-------|
| 210104 | Урамшуулал | 59,547.60 | 34,602.71 | 24,944.89 | 58.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 51,237.00 | 60,656.38 | (9,419.38) | 118.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,718.30 | 85,173.89 | 10,544.41 | 89.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,263.20 | 59,718.79 | 10,544.41 | 85.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,363.80 | 6,363.80 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,181.90 | 3,181.90 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,181.90 | 3,181.90 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,727.50 | 12,727.50 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 259,562.10 | 251,545.22 | 8,016.88 | 96.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,707.60 | 16,060.20 | 5,647.40 | 74.0 |
| 210302 | Түлш, халаалт | 235,124.00 | 233,271.00 | 1,853.00 | 99.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,730.50 | 2,214.02 | 516.48 | 81.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 65,005.00 | 59,182.97 | 5,822.03 | 91.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,850.00 | 3,831.31 | 18.70 | 99.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,364.00 | 50,115.21 | 2,248.79 | 95.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,350.00 | 1,506.96 | 2,843.04 | 34.6 |
| 210404 | Ном, хэвлэл | 691.00 | 191.00 | 500.00 | 27.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 750.00 | 580.00 | 170.00 | 77.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000.00 | 2,958.50 | 41.50 | 98.6 |
| 2105 | Нормативт зардал | 3,030.00 | 1,595.00 | 1,435.00 | 52.6 |
| 210502 | Хоол, хүнс | 510.00 | 510.00 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,520.00 | 1,085.00 | 1,435.00 | 43.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 94,689.50 | 77,249.92 | 17,439.58 | 81.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,720.00 | 15,215.70 | 5,504.30 | 73.4 |
| 210602 | Тавилга | 5,000.00 | 4,150.00 | 850.00 | 83.0 |
| 210604 | Урсгал засвар | 68,969.50 | 57,884.22 | 11,085.28 | 83.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,610.00 | 24,440.00 | 1,170.00 | 95.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,610.00 | 24,440.00 | 1,170.00 | 95.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,083.00 | 2,433.37 | 1,649.63 | 59.6 |

| | | | | | |
|-------------|--|---------------------|---------------------|-------------------|-------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 480.00 | - | 480.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008.00 | 604.80 | 403.20 | 60.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200.00 | 64.30 | 135.70 | 32.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 825.00 | 573.90 | 251.10 | 69.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110.00 | 110.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,430.00 | 1,060.00 | 370.00 | 74.1 |
| 210807 | Газрын төлбөр | 30.00 | 20.36 | 9.64 | 67.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 115,194.00 | 105,663.80 | 9,530.20 | 91.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,330.00 | 102,659.30 | 7,670.70 | 93.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,864.00 | 3,004.50 | 1,859.50 | 61.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 79,381.60 | 67,579.46 | 11,802.14 | 85.1 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 79,381.60 | 67,579.46 | 11,802.14 | 85.1 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 39,904.00 | 30,023.35 | 9,880.65 | 75.2 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,477.60 | 35,142.21 | 335.39 | 99.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000.00 | 2,413.90 | 1,586.10 | 60.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,387,087.30 | 509,933.43 | 877,153.87 | 36.8 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,387,087.30 | 509,933.43 | 877,153.87 | 36.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 90,000.00 | - | 90,000.00 | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 90,000.00 | - | 90,000.00 | - |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,969,007.30 | 2,380,993.68 | 588,013.62 | 80.2 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,407,685.60 | 2,223,212.24 | 184,473.36 | 92.3 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,523,867.80 | 1,388,282.42 | 135,585.38 | 91.1 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 883,817.80 | 834,929.82 | 48,887.98 | 94.5 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 561,321.70 | 157,781.44 | 403,540.26 | 28.1 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 177,061.60 | 151,307.44 | 25,754.16 | 85.5 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,000.00 | 6,474.00 | 23,526.00 | 21.6 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 354,260.10 | - | 354,260.10 | - |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|------------|--------------|--|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 466,781.36 | (466,781.36) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 971,971.81 | (971,971.81) | |

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөг)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 129,375.59 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 129,375.59 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 127,773.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,000.95 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000.95 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,565.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,565.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,208.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,208.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,601.64 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,601.64 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,601.64 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 129,375.59 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 129,375.59 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 127,289.59 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,086.00 |

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар алдаа илрээгүй болно.

Залруулагдаагүй нийт 9.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.1.1 Харьяа байгууллагууд

Алтай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 271.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг залруулж, 5.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 18.8 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 8.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 146.9 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:


Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

3.3 Албан шаардлага


1. Малд тоо толгойн албан албан татварын орлого 4.9 сая төгрөг, хөрөнгийн орлого 3.6 төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Алтай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоол," Алтай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 478.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 279.7 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 198.4 сая төгрөгийн төгрөгийн илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.



Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.



4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | БҮГД | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түвэрт | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|----------|-------------|----------------|----------|---------------------------|----------|-------------|------------------|---------------|----------------|-----------------|------------------|----------|-----------------|--------------------------------------|----------|---|-----|
| | | | | | | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Алтай сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 1 | - | 1 | - | - | - | 1 | 9,259.8 | - | 1 | 9,259.8 | - | - | - | - | - | - | |
| Алтай сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | 1 | - | - | - | 7 | 173,677.6 | 2 | 2,145.0 | 3 | 146,918.4 | 2 | 24,614.2 | - | - | - | |
| Алтай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | - | - | - | 1 | 1 | 577.0 | - | - | 1 | 577.0 | - | - | - | - | - | |
| Алтай сумын Орон нутгийн хөгжлийн сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 17,466.5 | - | - | 1 | 17,466.5 | - | - | - | - | - | |
| Алтай сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | |
| Алтай сумын Хоршоо хөгжүүлэх сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 6,636.0 | 1 | 5,800.0 | 1 | 836.0 | - | - | - | - | - | |
| Дүн | 6 | - | 2 | - | - | 4 | 12 | 207,616.9 | 3 | 7,945.0 | 7 | 175,057.7 | 2 | 24,614.2 | - | - | - | |

